



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар A/98


Алтай хот

**Терроризмтэй тэмцэх салбар
зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг
үзүүлэх тухай**

Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтэй тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2019 оны 460 дугаар тогтоолоор баталсан “Терроризмтэй тэмцэх зөвлөлийн ажиллах журам”-ын 7.2 дахь хэсэг, Терроризмтэй тэмцэх салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 06 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Аймаг дахь Терроризмтэй тэмцэх салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөт ажлыг гүйцэтгэхэд 10,000,000 (арван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.
2. Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Эрдэнэбат)-т зөшөөрсүгэй.
3. Зардлыг үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу зарцуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг аймаг дахь Терроризмтэй тэмцэх салбар зөвлөлд үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Алтанзагас)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР